



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

ШИНЭ АНАГААХ УХААН ИХ СУРГУУЛЬ
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН D091701
БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

2018 ОН

АГУУЛГА

НЭГ. ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА, ҮНДСЭН ҮЕ ШАТУУД	3
1.1. ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН	3
1.2. МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ҮЕ ШАТУУД.....	3
ХОЁР. МАГАДЛАН ШИНЖЛЭЛИЙН ҮР ДҮН.....	5
ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ	5
ШАЛГУУР 2. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ.....	9
ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	12
ШАЛГУУР 4. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	20
ШАЛГУУР 5. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	25
ШАЛГУУР 6. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	30
ШАЛГУУР 7. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ.....	34
ШАЛГУУР 8. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ	39
ГУРАВ.	
ХАВСРАЛТ.....	40

Товчилсон үгийн тайлбар

1	УАУ	Уламжлалт анагаах ухаан
2	ОУАУ	Орчин үеийн анагаах ухаан
3	NCM	Newly coded medicine
4	ХШБ	Хий шар бадган
5	АТФ	Аденозинтрифосфат
6	ЦУЭ	Цусны улаан эс
7	АДФ	Аденозиндифосфат
8	НАДФН	Никотинамидадениндинуклеотидфосфат
9	НАД	Никотинамидадениннуклеотид (исэлдсэн)
10	НАДН	Никотинамидадениндинуклеотид (ангижирсан)
11	ФАД	Флавинадениннуклеотид
12	БИБ	Биологийн идэвхит бүтээгдэхүүн
13	ҮФӨ	Үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл
14	СоQ	Коэнзим Q
15	ДНХ	Дезоксирибонуклейны хүчил
16	x	Хийсвэр билигдмэл код хэлбэрт таван махбодь, хий, шар, бадганы онолд суурилсан мэдлэг
17	g	УАУ-ы 20 билиг чанарын онолд суурилсан мэдлэг
18	s	Амьд эсийн талаархи орчин үеийн анагаах ухааны цогц мэдлэг
19	s-NCM	УАУ ба ОУАУ-ы нэгдмэл тогтолцооны NCM-д суурилсан шинэ мэдлэг
20	БНЛП	Бага нягттай липопротеид
21	ИНЛП	Их нягттай липопротеид
22	ХС	Холестерол
23	ТГ	Триглицерид
24	МТЧ	Мембраны тэсвэрт чанар
25	МиМ	Митохондрийн мембран
26	БМ	Бөөмийн мембран
27	ЛПМ	Лизосом-переоксисомын мембран
28	ПМ	Плазмийн мембран
29	ӨХИП	Өөхний хэт исэлдэлтийн процесс
30	МДА	Малондиальдегид
31	ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
32	СОААБ	Судас оношлогооны автомат анализатор багаж
33	ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
34	ТШУ	Техникийн шинжлэх ухаан
35	ТТАХНЭ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
36	ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
37	ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
38	ХБК	Хийсвэр билигдмэл код
39	УКТЭ	Улсын клиникийн төв эмнэлэг
40	СЭМТ	Сэтгэцийн эмгэг судлалын төв
41	ЭШБТ	Эсийн шинэ баяжуулсан тодорхойлолт
42	АПДК	Автоматический пульсовой диагностический комплекс
43	БХТХ	Биеийн хөндлөн тэнхлэгт хэсэг

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Шинэ анагаах ухаан их сургууль “New Medicine” Medical University	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Уламжлалт анагаах ухаан The syllabus of traditional medicine	
Индекс	D091701	
Шинжээчид	Ахлагчийн нэр, ажил, албан тушаал: Ахлагч: 1. Ч.Чимэдрагчаа – Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн захирал, академич Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: 2. Б.Даваажав – Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн ухааны сургуулийн профессор, доктор 3. Б.Цэрэнцоо – Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн багш, доктор	
БМИУЗ-ийн зохицуулагч	Зохицуулагчийн нэр, албан тушаал: Б.Мядагмаа – Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хариуцсан менежер	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Зохицуулагчийн гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2018.02.01- 2018.02.02	Шинжээчийн багийн ажлын хуваарийн дагуу явагдсан. Ажлын төлөвлөгөөг хавсралтаар оруулав.
Шалгуур шаардлага /журам/		

II. Сургалтын хөтөлбөрийн товч танилцуулга

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг шинжээчийн баг сургуульд ажиллахаас 14 хоногийн өмнө хүлээн авч, уншиж танилцсан. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан нь өмнөх үг, үндсэн 8 шалгуур, дэд шалгуур гэсэн бүтэцтэй, шалгуур бүрд PDCA циклийн дүгнэлт, SWOT шинжилгээ хийгдсэн. Шинжээчийн баг нь тайлангийн бүтэц, бичилтийн агуулга нь магадлан итгэмжлэлийн хөтөлбөрийн шаардлага, үзүүлэлтэд нийцэж байгаа эсэх, статистик судалгааны дүгнэлт, өгөгдлийн нотлох баримтууд зэргийг нягтлан үзэж,

урьдчилсан байдлаар тайланд тодорхойгүй байгаа хэсгүүдийг тодорхойлж, тодруулах асуултуудыг гаргаж бэлтгэв

III. Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт

/Хавсралтаар оруулав/

IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан**/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Шинэ анагаах ухаан их сургууль нь БСШУЯ-ны сайдын А/78, А/174, А/370, А285 тоот тушаалуудын дагуу бакалаврын 8, магистрын 4 хөтөлбөр сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан, сургалтын үйл ажиллагаа эрхлэн ажилласан байна.
- Шинэ анагаах ухаан дээд сургуулийн статусыг ангилал ахиулах ажлыг зохион байгуулж, зохих журмыг дагуу өөрийн үнэлгээний тайлан боловсруулан БМИҮЗ хүргүүлж, улмаар БСШУС сайдын 2017 оны 06 сарын 27 өдрийн А/42 тоот “Их сургууллийн ангилалд хамруулах тухай” тушаалаар 2017 оны 7 сарын 03-ны өдрөөс эхлэн их сургуулийн ангилалд багтжээ.
- Шинэ анагаах ухаан их сургууль нь “Уламжлалт анагаах ухаан” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Уламжлалт анагаах ухааны эмч нарын ажлын байрны эрэлт хэрэгцээ шаардлагын судалгаа явуулж, “Уламжлалт анагаах ухаан” хөтөлбөрийн шинэчлэлийг БСШУСЯ, Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд CDIO (conceive-сэтгэх, design-бодох, implement-бүтээх, operate-хэрэглэх), PDCA циклийн хүрээнд “21 зуун дахь уламжлалт анагаах ухааны боловсрол” **ген-энзим-субстрат-гадаад шинж хүний биеийн 20 билиг чанар, эм, заслын үйлдлийн 17 чадал, эрдэм-тэдгээрийг 5 махбодын онолоор тусган илэрхийлсэн байдал- тэдгээрийг хий, шар, бадганы онолоор тусган илэрхийлсэн байдал – 6 гол параметр танин**

мэдэхүйн бүтэн хэлхээ гурав гурваараа салангид байсныг s-NCM танин мэдэхүйн тайлалаар холбож протоны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээ шинэ онол дээр тулгуурласан NCM анагаах ухааны гурвалсан тогтолцоот сургалтын технологи хэрэгжүүлсэн байна.

- **Хөтөлбөрийн зорилгыг Онол, практик хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд чиглүүлэн тодорхойлж ажилласан байна.**
- NCM анагаах ухаан, NCM эмнэлзүйн анагаах ухаан, NCM эм зүй хичээлүүдийг 2-3 кредитээр нэмж оруулсан. Судалгааны 10 орчим лаборатори байгуулан, судалгааны үр дүнгээр асуудал дэвшигдэн оюутны мэдлэгийг чадваржуулан ажиллажээ.
- ШАУИС-ийн уламжлалт анагаах ухааны хүний их эмч мэргэжилтэн бэлтгэж байгаа бөгөөд 2014, 2015 онд төгссөн төгсөгчдийн дунд сургалтын хөтөлбөрийн давуу, сул талыг судлан үзэхэд хөдөлмөрийн зах зээлд зохицох байдал 31.7 хувь нь сул талтай гэж үнэлгээ өгсөн байна. Бусад мэргэжил хөтөлбөрөөр суралцах байдал сул байгаа нь анагаах ухааны сургалтын хөтөлбөрөөр суралцах хугацаа харьцангуй урт байгаатай холбоотой гэж үзсэн байна.
- Хөтөлбөр сайжруулах зорилгоор 7 хоногт 100 гаруй оюутан, 20 гаруй багштай урт богино хугацааны ярилцлага зохион байгуулсан байна. Ярилцлага, тэмдэглэл хөтөлбөр сайжруулах зорилгоор хийсэн уулзалтад багш, оюутан, төгсөгчид, ажил олгогчдыг оролцуулан саналыг тусган ажилласан байна.

Анхаарах асуудал:

- Уламжлалт анагаах ухаан эмч мэргэжилтний хэрэгцээ шаардлага ямар байгааг судалж тогтоосон судалгаа хийсэн боловч хөтөлбөрт холбож уялдуулах тал дээр бага зэрэг дутагдалтай ажилласан байна гэж үзэж байна.

Зөвлөмж:

- Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй өнөөгийн тогтолцоог салбарын харьяалах яам, газруудад, энэ чиглэлд хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэхийн зэрэгцээ энэ чиглэлийн төрөлжсөн нарийн мэргэжлийн хөтөлбөр стандартыг боловсруулж холбогдох газруудаар батлуулан хэрэгжүүлэх
- ШАУИСургуулийн уламжлалт анагаах ухааны хүний их эмч мэргэжилтэн бэлтгэж сургалтын хөтөлбөрийн давуу, сул талын судалгааг тодорхой давтамжтай явуулж, хөдөлмөрийн зах зээлд зохицох байдал 31.7 хувь нь сул талтай байгаад дүн шинжилгээ хийж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал

-
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байх шаардлагын хүрээнд:
 - БМИҮЗ-ийн ерөнхий шалгуур
 - Засгийн газрын Дээд боловсролын талаар баримтлах бодлого
 - БШУС-ын А/78, А/174, А/370 тоот тушаал
 - БМИҮЗ-ийн даргын 2015 оны 02 тоот тушаал
 - Азийн Хөгжлийн банкны Дээд боловсрол шинжлэлийн төслийн шинжээчдийн дүгнэлт зэргийг үндсэн баримт болгон БСШУЯ-ны сайдын А/78, А/174, А/285 тоот тушаалуудын дагуу 2013 он (УАУ-D722000, эм зүй-D723400), 2014 он (УАУ-D0917018, ЭЗ-D091601) сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнүүд өөрчлөгдөж, шинэчлэгдсэнтэй холбогдуулан сургуулийн багш тус бүрээр өөрийн заадаг нэгж хичээлийн хөтөлбөрийг сургуулийн шинэ нээлт, шинэ мэдлэг, шинэ үзэл баримтлал, шинэ арга зүй болон шинэ загварыг тусган боловсруулах, батлуулах ажлыг 1-3 удаа зохион байгуулсан байна.
- Хөтөлбөрийн дэвшилтэт хандлага хичээл нэг бүр дээр багш сэтгүүлэн заах аргыг давамгайлан хэрэглэдэг. “нэг эхлэлээс хэдэн арван тооны салаалсан шинэ санааг олох” гэсэн хувилбарыг дадлагын хичээлд ашигладаг.
- Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго, сургалтын төлөвлөлт нь онол практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн, танин мэдэхүйн цоо шинэ тайллаар дамжуулан уламжлалт ба орчин үеийн анагаах ухаан, NCM анагаах ухааны гурвалсан тогтолцоот сургалтын технологийг бий болгон сургалтанд ашиглаж, эмч, мэргэжилтнүүдээ чадваржуулахад бүрэн чиглэгдэж, хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан байна.
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг ЭМЯ, ЭМХТ-ийн эмнэлгийн ажилтны хөгжүүлэх албанаас зохион байгуулан авдаг төгсөгчдийн эмчлэх эрхийн зөвшөөрөл авах шалгалтын дүнгээс харахад мэргэжлээр төгсөгчдийн үзүүлсэн амжилт сүүлийн 7 жилийн дундажаар 80.9 байгаа, Уламжлалт анагаах ухааны их эмч мэргэжлээр төгссөн төгсөгчдийн онолын шалгалтын дүн 86.84 (3.3) байгаа нь сургалтын хөтөлбөр үр дүндээ хүрч чадаж байгааг нь тус хөтөлбөр төлөвлөлт үр дүндээ хүрч чадаж байгаа харуулж байна гэж үнэлжээ.
- Ажил олгогчдийн зүгээс хамгийн өндөр сэтгэл ханамжтай ур чадвараар төгсөгчдийн харилцааны ур чадварыг онцолж байгаа нь тус сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгад буй харилцааны сэтгэл, анагаах ухааны зурхай, эмнэлгийн эрх зүй, оюуны өмчийн эрх зүй, эмчийн эрхзүй зэрэг харилцаа, хандлага, ёс зүйн хичээлүүд түлхүү орж байгаатай холбоотой гэж үзсэн байна.

Анхаарах асуудал:

- ДЭМБ болон Ази номхон далайн бүсийн орнуудын уламжлалт анагаах ухааны стратеги, бодлоготой уялдуулах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал нь ДЭМБ болон Ази номхон далайн бүсийн орнуудын уламжлалт анагаах ухааны стратеги, бодлоготой уялдуулах
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулж ажиллах

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

-“Шинэ анагаах ухаан” их сургуулийн “Уламжлалт анагаах ухаан” хөтөлбөрийн БСШУСЯ, Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд:

1. “Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох арга зүйн зөвлөмж” Н.Эрдэнэхүү нар. 2017

2. “Нийлмэл сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөмж” Н.Эрдэнэхүү нар. 2017.

3. “Багш нарын хувь хүний болон багшлахуйн чадварын дээшлүүлэх арга зүйн зөвлөмж” Д.Энхтуяа 2017

-CDIO (conceive-сэтгэх, design-бодох, implement-бүтээх, operate-хэрэглэх)- Н.Эрдэнэхүү нар. 2017

-Сургах, суралцахуйн үйл ажиллагаа (TLAs-Teaching and learning Activities),

-Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтууд (PEOs-Program Educational Objectives) Н.Эрдэнэхүү нар. 2017

-Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLOs-Program learning outcomes) Н.Эрдэнэхүү нар. 2017

-Хичээлийн суралцахуйн үр дүнгүүд (CLOs-Course Learning Outcomes) Н.Эрдэнэхүү нар. 2017

-Үр дүнд суурилсан боловсрол (OBE-Outcome based education)- Н.Эрдэнэхүү нар. 2017 арга зүйн зөвлөмжийг дагуу Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго, сургалтын төлөвлөлт нь онол практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн, танин мэдэхүйн цоо шинэ тайллаар дамжуулан уламжлалт ба орчин үеийн анагаах ухаан, NCM анагаах ухааны гурвалсан тогтолцоот сургалтын технологийг бий болгон

сургалтанд ашиглаж, эмч, мэргэжилтнүүдээ чадваржуулахад бүрэн чиглэгдэж, хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусган ажилласан байна.

Тус сургууль нь дараахь шинэ онолыг хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байгаа юм байна.

- Мембран редокси потенциалын 3 төлөвт шугамын онол
- Хүний биеийн 4 компартмент бүтцийн онол
- Эсийн шинэ баяжуулсан тодорхойлолтын онол
- Протоны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээний онол
- Амьд эсийн эволюци хөгжлийн сүүлийн 4 тэрбум жилийн систем хандлагын онол
- Дөрвөн гол хувилбарт эсийн популяцийн онол
- NCM–д суурилсан Уламжлалт анагаах ухааны сургалтын хөтөлбөрийн шинжлэх ухааны танин мэдэхүйн гол үндэслэл нь IF (7 оос дээш) өндөртэй сэтгүүлд 30 гаруй өгүүллийг дээрх онолын хүрээнд нийтлүүлсэн байна.
- Тус сургуулийн уламжлалт анагаах ухааны хүний их эмч мэргэжилтэн бэлтгэж байгаа бөгөөд 2014, 2015 онд төгссөн төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар Бизнес эрхлэх ур чадвар дээр сэтгэл ханамж бага байгаа нь анагаах ухааны мэргэжлийн онцлогтой холбоотой байна. Тиймээс цаашид төгсөн гарч буй төгсөгчийн бизнес эрхлэх чадваруудыг хөгжүүлэх тал дээр анхаарч 2016 оны УАУ-091701-ийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахдаа эдийн засгийн онол 1 кр, менежмент 1 кр, эмнэлгийн удирдлагын менежмент 1 кр гэсэн 3 хичээлийг сонгон судлах хичээлээр судлуулж байгаа ажээ.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдалд хяналт тавьж ажиллах

Зөвлөмж:

- Цаашид төгсөн гарч буй төгсөгчийн бизнес эрхлэх чадваруудыг хөгжүүлэх тал дээр анхаарч
- Гадаад, дотоодын төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтанд хамрагдалтын судалгаа явуулж, дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах
- Хувь хүний хөгжил сурах арга барил дээр хослуулан хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

-
- Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал
 - Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал
 - Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага

Шинэ анагаах ухаан их сургууль нь өмнөх магадлан итгэмжлэлийн дүгнэлтээр 1 оюутанд ноогдох сургалтын орчны хэмжээ 2.8м² байсан ба сургалтын бааз барилгуудыг шинээр ашиглалтанд оруулснаар 3.63м², нэг суудалд оногдох лабораторийн талбай 2,9 м² болж нийт талбайн хэмжээ 1.74 дахин нэмэгдсэн нь дээд боловсролын байгууллагад тавигдаж буй стандарт шаардлагын хэм хэмжээг хангаж байна.

Тус сургууль нь багш оюутны сургалт, судалгаа явуулах, өөрийгөө хөгжүүлэх, хэрэгцээтэй мэдээ мэдээллээр хангагдах, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, эрүүл, аюулгүй орчныг сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, эмнэлэг үйлчилгээнээс олсон орлогоос зарцуулж хөрөнгө оруулалт хийсэн байна. Ялангуяа, багш оюутны эрүүл мэндийг дэмжих, оюутнуудад судалгааныур чадвар олгох, бие даан суралцах нөхцөл бололцоог хангах зорилгоор техник технологийн дэвшил, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дотоод нөөц бололцоогоо ашиглан, сургуулийн орчныг шинэчлэн зохион байгуулах талаар тодорхой бүтээлч ажлуудыг хийж хэрэгжүүлжээ. Үүнд:

- 2015 онд 2000 гаруй м² талбай бүхий 7 давхар хичээлийн шинэ байрыг ашиглалтанд оруулсан.
- Хэнтий аймагт 14 га бүхий эмийн ургамал тарималжуулах, судалгаа сургалтын биостанц шинээр байгуулсан. Сүүлийн 5 жилд 350 гаруй оюутан дадлага хийж, 23 багш ажиллажээ.
- 40 ортой “Амбага доктор” нэртэй иж бүрэн сувилал ашиглалтанд оруулж сургалтанд ашиглаж байна. 2016 онд 4 багш, 2 оюутан дадлага хийсэн байна.
- 30 ор бүхий “Хулж боржигон” бааз эмнэлгийг өргөтгөн сайжруулж материаллаг баазыг бэхжүүлсэн. Тус эмнэлэгт жил бүр 80-120 оюутан дадлага хийсэн байна.
- Биохимийн, биологиургамалсудлалын, фитохимийн, гистологигистохимийн, микробиологийн, эмийн технологийн, мембранредокси судлалын зэрэг сургалт судалгааны лабораториуд, СОААБ оношлогооны кабинет шинээр байгуулж 444.003.314 төгрөгний хөрөнгө оруулалт хийсэн.
- Багш бүрт 1 компьютер, бие даалтын өрөөнд 1 оюутан, 1 компьютер, өндөр хурдны Wireless интернеттэй холбосон, сканер, зөөврийн хард, принтер, Kasperski антивирусын программаар бүрэн хангасан байна.
- УБ хотын томоохон клиник, төрөлжсөн эмнэлэг 15, нийслэлийн 51 өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гэрээ байгуулан ажиллаж байна. 2012-2017 онуудад эмнэлгүүд дээр дадлагжсан оюутны тоо (давхардсанаар) 46439 хүрсэн байна. Гэрээт эмнэлгүүдийн үр дүнгийн урамшуулал төлбөрт 73984000 төгрөг зарцуулжээ.
- Сургуулийн номын санд цахим номын сангийн Коһа лицензтэй программыг 2016 онд ашиглалтанд оруулснаар сүүлийн 2 жилд 1900 орчим багш, оюутнууд үйлчлүүлсэн байна. Номын сангийн сурах бичиг гарын авлагын хангалт баяжилт сүүлийн 5 жилд нэмэгдсэн үзүүлэлттэй бөгөөд 2017 оны байдлаар

сурах бичиг 6431, гарын авлага 10234, ЭШ-ний сэтгүүл, бүтээл 2057, цахим эх үүсвэр 174 тус тус байна.

- 2015 онд сургуулийн гадаад, дотоод орчны тохижолтонд анхаарч бут мод сөөг тарьж зүлэгжүүлэн, ногоон байгууламж байгуулан СХД-ийн “Шилдэг тохижолттой байгууллага”-аар шалгарч 5 сая төгрөгөөр шагнуулжээ.
- Хичээл сургалт явуулдаг анги танхимыг засаж, тохижуулан, LCD, проектороортоноглож, интернет орчинд чөлөөтэй нэвтрэн, хэрэгцээтэй мэдээллийг авах орчин нөхцөлөөр хангасан байна.
- Дээд боловсролын сургалтын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага”-ын хүрээнд 2.5.4-т заасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, багш, оюутныг нэвтрүүлэх зориулалтын шат, ариун цэврийн өрөөтэй байна” гэсэн заалтын дагуу орчныг тодорхой хэмжээнд тохижуулсан байна.

Зөвлөмж:

Уламжлалт анагаах ухааны чиглэлээр гарч буй мэргэжлийн сэтгүүлүүд, ном сурах бичгийн хангалтыг нэмж хийх

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж
- Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургууль нь багш оюутныг сургах, сурах үйл ажиллагаанд шаардлагатай программ хангамж, хичээлийн хэрэгсэл, ном, гарын авлагаар бүрэн хангасан байна. Ялангуяа NCM анагаах ухааны чиглэлийн ном сурах бичиг гарын авлага, онолын тайлал бүхий зурагт үзүүлэн, оношлогооны материал зэргийг бүрдүүлж сургалт судалгаанд чөлөөтэй хэрэглэх боломжийг хангажээ.
- Мөн сургалтанд лицензтэй, өндөр төлбөр бүхий Uniface, Док-Ам 1,2,3,4,5 программ, хүүхдийн өвчний цогц менежментийн сургалтын программ, судас оношлогооны автомат анализатор багаж, санхүүгийн Veritech erp, номын сан, мэдээллийн Lib4U, Коха, HINARY программ, Uptodate.com эмнэлзүйн сургалтын вэб сайтыг ашиглаж байна. Сургалтанд хэрэглэх гарын авлага, дадлагын хичээлийн алгоритм, үйлдвэрлэлийн дадлагын удирдамж, 1000 гаруй хэвлэмэл үзүүлэн, эдийн макро, микро бэлдмэлийг сургалтанд ашиглаж байна.
- Сүүлийн 3 жилд проектор 7, зурагт радио 4, ухаалаг самбар 1, СОААБ-1-ийг сургалтын үйл ажиллагаанд нэмэгдүүлсэн байна.
- Шинэ онол нээлттэй холбоотой мэдлэгийн орчин, мэдээллийн сан, энэ чиглэлээр бичигдсэн 200 гаруй ном сурах бичиг, гарын авлага, эмчилгээ оношлогооны стандартууд, судалгааны арга зүйнүүд, нэг сэдэвт бүтээлүүд, шинэ эмүүд, оюуны эрхийн хамгаалалт, ИФ өндөртэй сэтгүүлд хэвлэгдсэн 30 гаруй эрдэм шинжилгээний

өгүүлэл, номнууд, Ж.Шагж, Ц.Хайдав, Д.Ням-Осор, С.Хандсүрэн, Д.Самбуупүрэв зэрэг нэрт эрдэмтдийн нэрэмжит булан, лаборатори, өрөө танхимыг бий болгосон байна.

Зөвлөмж:

- Симуляци виртуаль лабораторийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ
- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
- Цахим орчны хүртээмж, хэрэглээ
- Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал
-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

• Шинэ Анагаах ухаан их сургуулийн номын сан электрон номын сан, оюутны уншлагын чөлөөт сонголттой танхим, интернет кафе, тогтмол хэвлэлийн булан, CD, видео, DVD, аудио сан, архив, гэрээр ном олгох танхимтай байна. DDC ангиллыг нэвтрүүлж зүйлчилсэн каталогтай болсон. УАУ сургалтын хөтөлбөрийн хүрээнд 23900 ном ашиглаж байна. Электрон хэлбэрээр ашиглах номын фонд 165 байна. Жил бүр гадаад, дотоодын 8-10 мэргэжлийн сэтгүүлийг захиалан ашиглаж байна.

Сургуулийн номын санд цахим номын сангийн Коһа лицензтэй программыг 2016 онд ашиглалтанд оруулснаар сүүлийн 2 жилд 1900 орчим багш, оюутнууд үйлчлүүлсэн байна. Номын сангийн сурах бичиг гарын авлагын хангалт баяжилт сүүлийн 5 жилд нэмэгдсэн үзүүлэлттэй бөгөөд 2017 оны байдлаар сурах бичиг 6431, гарын авлага 10234, ЭШ-ний сэтгүүл, бүтээл 2057, цахим эх үүсвэр 174 тус тус байна.

Мөн хөтөлбөрийн үндсэн суурь болсон шинэ онол нээлт, үзэл баримтлалтай холбоотой энэ чиглэлээр бичигдсэн 200 гаруй ном сурах бичиг, гарын авлага, эмчилгээ оношлогооны стандартууд, судалгааны аргазүйнүүд, нэг сэдэвт бүтээлүүд, шинэ эмүүд, оюуны эрхийн хамгаалалт, IF өндөртэй сэтгүүлд хэвлэгдсэн 30 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл зэргийг сургалтанд судалгаанд ашиглаж байгаа нь хөтөлбөрийн хүрээнд сургалтыг бодитой үр дүнтэй явуулах нотолгоо болж байна.

Зөвлөмж:

Цаашид уламжлалт анагаах ухааны ховор эх сурвалжуудыг цахим хэлбэрт оруулан сургалтанд ашиглах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал
- Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт
- Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

• Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлсэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлж байна. Үүнд: хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэдээллийн тогтолцоо буюу их сургуулийн удирдлага, мэдээллийн Uniface программыг системийг нэвтрүүлснээр сургалтын бодлого зохицуулалтын газар, багш, суралцагчид хоорондын харилцаанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах боломж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, сургалтын мэдээллийн нэгдсэн санг бий болгох зорилгыг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд багш, оюутнуудын дунд уралдаан хэлэлцүүлэг зохион байгуулдаг. Мөн ажил олгогчдоос санал асуулга авч дүн шинжилгээ хийж ажилласан байна. 2012-2016 онуудад төгсөгчдийн гаргасан саналд үндэслэн мэдрэл, эх барих, эмэгтэйчүүд, өрхийн анагаах ухааны цагийг нэмэгдүүлсэн, клиник эм судлал, гэмтэл согог судлал, хавдар судлал шинэ хичээлүүдийг төлөвлөгөөнд тусгасан. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр NCM-AU-ны эмнэлзүйн аспект, УАУ эмгэг судлалын суурь, УАУ эм найрлагын судлал, УАУ таван эрхтэний өвчин судлал, УАУ эмэгтэйчүүд хүүхдийн өвчин судлал, УАУ хөнгөвчлөх эмчилгээний асуудал, Зүү сүвийн байршил зүй, УАУ гэмтэл судлал, УАУ бариа засал судлал, Философи, Монголын түүх, Монгол хэлний найруулга зүй, Биеийн тамир, гамшгаас хамгаалах зэрэг хичээлүүдийг

хөтөлбөрт нэмж тусгасан байна. Англи хэл, төвөд хэлийг 4-5 семестр зааж улсын шалгалт авдаг болсон зэрэг шинэчлэлтүүдийг хийжээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тус сургуулийн дүрэм журмын хүрээнд хөтөлбөрийн баг, сургалтын бодлого зохицуулалтын алба, багшлах боловсон хүчин, оюутан суралцагч нар хамтран ажилладаг бөгөөд Дотоод чанарын баталгаажилтын алба үе шаттайгаар хяналт тавин зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилладаг. Оролцогч сонирхогч талуудын тавьсан саналын дагуу NCM хичээлийн дадлагын цаг, NCM эмнэлзүй хичээлийн цагийг тус тус нэмэгдүүлсэн байна.

Багшийн хөгжүүлэх бодлоготой, дэмжлэг туслалцаа үзүүлдэг, судалгаа, сургалт, үйлдвэрлэл гэсэн цогц үйл ажиллагаанд хамруулдаг, урамшуулал хөшүүргийн систем тогтсон зэрэг нь ахиц дэвшил болж чадсан байна.

Зөвлөмж:

NCM анагаах ухааны онол үзэл баримтлалд тулгуурлан боловсруулсан хөтөлбөрийн үр дүн практик үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор практикт нэвтрүүлэх асуудлыг анхааран ажиллах

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Хөдөлмөрийн зах зээлд УАУ, орчин үеийн анагаах ухаан, NCM анагаах ухааны гурвалсан тогтолцооны мэдлэг чадвар бүхий эмч, сувилагч нарыг бэлтгэн цоо шинэ чадамж бүхий эмч мэргэжилтний эрэлт хэрэгцээ нэн чухал байгаа тул эдгээр чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж, хэлэлцүүлэх шаардлагатай байгааг бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан онцолсон байна.

Шинэ анагаах ухаан их сургууль нь хөтөлбөрийг сурталчлах хүрээнд NCM анагаах ухаан, шинэ мэдлэгийн чиглэлээр багш нарт жилдээ 6-аас доошгүй, оюутнуудад 2 сард 1 удаа, давхардсан тоогоор сүүлийн 3 жилд 5000 гаруй багш, оюутан төгсөгчид, эмч нарт мэдээлэл хийж, 250 орчим ном, жижиг гарын авлага хэвлүүлсэн, телевизээр 10 орчим ярилцлага хийгээд байна. Холбогдох 7-8 эмнэлгүүдэд сургалтын хөтөлбөрийн хүрээнд сургалт семинар, мэдээлэл байнга хийдэг байна. 2015-2016 онуудад уламжлалт эмийн, ерөнхий анагаах ухааны, онош зүйн, сэтгэц мэдрэлийн эмгэг судлалын, эм судлал, клиник эм судлал, NCM эм зүйн тэнхимүүдийг тус тус байгуулсан. Мөн хөдөлмөрийн зах зээлийн тандалт судалгааг хийсэн. Хөтөлбөрийн багийн тасралтгүй судалгааны үр дүнд бий

болсон шинэ мэдлэг, онол, санааг хөтөлбөрт тусган баяжуулалт хийдэг. Үүнээс улбаалж бичиг баримт шинэчлэн боловсруулах, багш, орчинг бэлтгэх, оношлогоо эмчилгээний стандартыг шинэчлэх сайжруулах, сургалтын зориулалт бүхий эмнэлзүйн, дадлагын баазуудыг нэмж байгуулах ажлууд хийгдэж байна.

Багш нарын ЭШ-ний бүтээлийг зах зээлийн эргэлтэнд оруулахад БСШУСЯ, ЭМЯ, ШУТС, Улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд тус сургуулийн багш нарын бүтээлүүд зах зээлд борлогдож сургуулийн зардлын тодорхой хувийг санхүүжүүлж байна.

Зөвлөмж:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандалт судалгааг нарийвчлан гаргаж, дүн шинжилгээг хийх

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал
-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

• Шинэ анагаах ухаан их сургууль нь 12 удаагийн төгсөлтөөр 801 уламжлалт анагаах ухааны эмч төгсөж, 705% нь ажил эрхэлж байна. Төгсөгч нар бүх шатны эрүүл мэндийн байгууллагад эмч, тасгийн эрхлэгч, ерөнхий эмч хийж байна. Төгсөгчдийн 20 орчим хувь Европ анагаах ухааны чиглэлээр, 10 гаруй хувь нь зүү төөнө заслын чиглэлээр ажиллаж байна. Түүнчлэн төгсөгчид магистрантур, докторантурт суралцахын зэрэгцээ, докторын зэрэг 4, магистрын зэрэг 10 хүн хамгаалжээ. Мөн 4 эмч ОХУ-ын Новосибирск хотод, 1 эмч Сочи хотод, Польш улсад 3 эмч мэргэжлээрээ ажиллаж буй нь гадаад, дотоодын уламжлалт анагаах ухааны салбарт хүч хөдөлмөрөө зориулан ажилладаг тоо баримт байна. Төгсөгчдийн лицензийн шалгалт өгсөн амжилт 95-100% байгаа нь сургалтын чанарыг илтгэх үзүүлэлт юм. Төгсөгчдийн холбоог 2010 онд байгуулан ажиллахын зэрэгцээ төгсөгчдийн мэдээллийн нэгдсэн сантай болсон байна. Төгсөгчидтэй уулзалт ярилцлага зохион байгуулах, тэдний санал бодлыг авах шаардлагатай бол хөтөлбөрт тусган ажиллажээ. Шинэ анагаах ухаан их сургууль дээр төгсөлтийн дараахи багц цагийн сургалтыг жилд 3-4 удаа тогтмол зохион байгуулжээ. Төгсөгчдийн холбоо БСШУСЯ-наас хэрэгжүүлж буй Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд Төгсөгчдийн мөшгих судалгаа-1, 2 төслийг хэрэгжүүлж төгсөгчдийн талаархи мэдээлэл, үр дүнг гарган авчээ.

Төгсөгчдөөс онлайн судалгааг тогтмол авч байна. 2012-2017 онуудад хийгдсэн онлайн судалгаанд 259 төгсөгчид хамрагдсан байна.

Ажил олгогчид, төгсөгч нартай хийсэн уулзалтаас харахад мэргэжлийнхээ үнэ цэнэ, мэргэжилдээ дур сонирхолтой байх, мэргэжлээрээ бахархах, цаашид өсөн дэвжих хүсэл тэмүүлэл итгэл үнэмшил өндөртэй, ажил олгогч нар сэтгэл хангалуун байсан. Мөн төгсөлтийн дараахи сургалтын хувьд УАУ-ны эмч нар өрнийн анагаах ухаан руу хөрвөн суралцах боломжийг олгох шаардлагатай гэсэн санал хүсэлт их гарч байсан.

Зөвлөмж:

- УАУ-ны чиглэлийн болон Орчин цагийн анагаах ухааны сургуулиудад NCM анагаах ухааны хичээлүүдийг оруулдаг болох
- Төгсөлтийн дараахи төрөлжсөн нарийн мэргэжил олгох сургалтанд NCM анагаах ухааны чиглэлийг оруулж хөтөлбөр стандартыг батлуулах сургалтыг зохион байгуулах

3.4. Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо
- Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

• Олон улсын хамтын ажиллагааны хувьд гадаадын зарим их, дээд сургууль, судалгааны болон мэргэжлийн байгууллагатай холбоо тогтоож багш, суралцагч солилцох, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтарч ажилладаг байна. Тухайлбал:

- 2012-2017 онуудад ОХУ-ын Томскийн АУИС, Буриадын их сургуулийн АУДС, Буриадын ДДАУ Төв, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Байгалийн ба сорилын биологийн хүрээлэн, Бээжин хотын Хятад эмнэлэг-Эмийн их сургууль, Тяньжинь хотын АУИС, Хөх хотын Хятад Монгол эмнэлгийн хороо, Тунляо хотын Үндэсний их сургуулиудтай сургалт судалгаа хамтын ажиллагааны чиглэлээр гэрээ байгуулан ажиллаж байна.
- Сүүлийн 5 жилд 142 оюутан ОХУ, БНХАУ-ын холбогдох их дээд сургууль, эмнэлэгт дадлага хийсэн байна. Мөн 22 багш ажилтан гадаадад явж мэргэжил дээшлүүлсэн байна.

Зөвлөмж:

- Цаашид гадаадтай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлж багш оюутны оролцоог ханган ажиллах

- Төгсөгчдийг гадаадын тэтгэлэгтэй сургалт, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт оролцуулах ажлыг зохион байгуулах

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

• Шинэ анагаах ухаан их сургууль нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна. Дотоод хамтын ажиллагаанд УНТЭ, ХӨСҮТ, ХСҮТ, ЭХЭМҮТ, БХХСАХНЭ, Энэрэл эмнэлэг, СХД-ийн Эрүүл мэндийн төв, ТТАХНЭ, ГССҮТ, ХУД-ийн нэгдсэн эмнэлэг, 10 гаруй өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулсан байна.

Мөн БСШУСЯ, ЭМЯ, ШУТС, МАУБХ, МХЕГ-ын үндэсний лавлагаа лаборатори, Ханлаб, Грийн химистри, Цэцүүх ХХК, Мон-Алтиус ДС, Скаймедиа ХХК, Монросцветмет, Хэнтий аймгийн Мөрөн сумын эмнэлэг, Цэнхэрмандал, Баянмөнх зэрэг сумуудтай хамтран ажилладаг.

ШАУИС-ийн Хулж боржигон эмнэлэг, Бор-Өндөр дэхь Амбага доктор сувилал нь жилдээ 700 гаруй өвчтөн сувилуулагчдыг хүлээн авч тусламж үйлчилгээ үзүүлж байна.

Энэрэл эмнэлэгтэй хамтран орон гэргүй хүмүүст туслах, хувцас, эм бэлдмэл хандивлах, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх зэрэг ажлуудыг хийжээ.

ШАУИС-ийн эрдэмтэн багш нар оюутан судлаачид хамтран 2011 оноос хойш УАУ-нд суурилсан шинэ эм, олон найрлагтай эмүүдийн хими, фармакологи, технологи, стандартын чиглэлийн инновацийн, цөм технологи, ШУТ, захиалгат төслүүдийг БСШУС-ын яамны санхүүжилтээр хэрэгжүүлсээр ирсэн байна. Төслүүдийн үр дүнд олон шинэ эм, биологийн идэвхит бүтээгдэхүүн практикт нэвтэрсэн байна. Эдгээрийн судалгаа шинжилгээний ажлыг 180 гаруй оюутнууд, 42 багш судлаачид хамтран хийжээ.

Зөвлөмж: НСМ анагаах ухааны чиглэлээр оношлогоо эмчилгээний удирдамж гарган мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо

-
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
 - Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
 - Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

ШАУИС-ийн төсвийн орлого бүрдүүлэлт нь сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний ажлаас олох орлого, үйлдвэрлэлээс олох орлого 80:10:10 гэсэн харьцаатай байна. Цаашид энэ харьцааг 70:15:15 гэсэн харьцаатай болгох зорилт тавин ажиллаж байгаа нь ололттой байна.

Нэг оюутанд оногдох зардал тасралтгүй өссөн бөгөөд 2017 оны байдлаар 1.485.600 төгрөг байна. Сүүлийн 5 жилд докторантурт суралцсан багш нарт 5 сая төгрөгний тэтгэлэг олгосон байна. Багш нарыг сурган заах аргазүйн дамжаанд суралцуулж 2.320.000 төгрөгний сургалтын төлбөрийг тус их сургууль хариуцжээ.

Мөн сүүлийн 5 жилийн хугацаанд ном сурах бичиг, гарын авлага, ЭШӨ хэвлүүлэх, гадаадад ном, ЭШӨ хэвлүүлэхэд нийт 34.874.380 төгрөг зарцуулсан байна.

Сүүлийн 3 жилд сургалт судалгааны зориулалт бүхий 7 шинэ лаборатори (Хулж боржигон эмнэлэг, Цэнхэрмандалын “ га биостанци, эрдэм шинжилгээ инновацийн төв, Хэрлэн баян улааны 10 га био хүрээлэн, Бор өндөрийн 40 ортой Амбага доктор сувилал, DR.Ambaga ХХК, Саран Үр гарааны ХХК) байгуулахад 250.000.000 сая төгрөг зарцуулжээ.

Багш ажилчдад хүүгүй зээл олгодог, ажлын хувцас, бичиг хэргийн зардал, ном гарын авлага хэвлүүлэх зардлыг хариуцдаг зэрэг санхүүгийн бодитой дэмжлэгийг үзүүлжээ.

Оюутнуудын нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа, соёл хүмүүжлийн ажил, материаллаг баазаар хангах, гадаад дотоод дадлагын ажилд сургалтын төлбөрийн 25%-ийг зарцуулдаг байна.

“Амбага доктор” сувиллын эмчилгээ үйлчилгээ үзүүлэх тендерээс 100 сая, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тендерээс 200 сая, Нефромон, салимон эмийн борлуулалтын орлого 50-60 сая, Хулж боржигон эмнэлгийн үйл ажиллагаанаас 10 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэн сургалт, судалгаа, эмчилгээ сувиллын үйл ажиллагаанд зарцуулжээ.

Зөвлөмж:

Дотоод гадаадын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэн оюутны байр, ур чадварын төвийг байгуулах, материаллаг баазыг улам сайжруулах асуудлыг анхааран ажиллах

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- “Шинэ Анагаах Ухаан” их сургууль нь элсэгч нэг бүртэй тулж ажиллан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, сурах арга барил эзэмшүүлэх, бие даан сурах чадамжийг нэмэгдүүлэх чиглэлд мэргэжлийн тэнхим, нэгж албад, багш нараас гадна оюутны зөвлөл, оюутны сайн дурын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, арга зүйн болон санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлэн ажиллаж байна. Үүний зэрэгцээ оюутны хичээлээс гадуурх нийгэмд хандсан үйл ажиллагааг дэмжих, амжилттай сайн сурсан оюутныг урамшуулах, оюутны санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор цагийн болон улирлын чанартай ажлын байраар хангах, сургалтын төлбөр төлөлтийг уян хатан болгох, оюутанд дарамтгүй ээлтэй сургууль болох гэсэн уриаг хэрэгжүүлэн ажиллаж байна.

-“Анагаах ухаан” хөтөлбөрийн биологи, хими, математик, англи хэлний хичээлийн шалгалтыг шалгуур үзүүлэлт болгосон байна.

-Элсэгчдийн шалгалтын дундаж оноо нь улсын дундаж онооны түвшинд байна.

-Элсэгчид, сургууль хамт олонтой танилцах 7 хоногийн ажлыг оюутны албанаас удирдан зохион байгуулдаг нь хамт олныг төлөвшүүлэхэд оршиж байна.

4.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэхүйлчилгээнийтөлөвлөгөө, график, үрдүн
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт

- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал
- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдад зөвлөх, хөгжүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулдаг байна.
- Зөвлөх багш, сургалтын менежер, сургалтын туслах ажилтан нар оюутанд үзүүлэх боловсролын үйлчилгээний чанарын үнэлгээний судалгааг хийх шаардлагатай.
- Бие хүнийг төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй дээд боловсролын еранхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийн залгамж чанарыг илэрхийлжээ.
- Нийгэм, хүмүүнлэгийн сайн дурын үйл ажиллагаа, ажлыг зохион байгуулдаг оюутныг батламж, өргөмжлөлөөрурамшуулан шагнадаг.
- Оюутан хөдөлмөр эрхлэхэд зуучлах, төгсөгчдийг ажлын байраар хангахад чиглэсэн үйл ажиллагааг явуулж байна.
- Оюутны судалгаа шинжилгээний цогц арга зүйг боловсруулан, тэднийг судалгааны ажил хийх, илтгэл бичих, хуралд хэлэлцүүлэх, хэвлэхэд дэмжлэг үзүүлдэг.

4.3. Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны зөвлөл хариуцсан багш нь тэдний санаачилсан ажлыг дэмжин, сургуулийн удирдлагад мэдээлэх, ажлын төлөвлөгөөг батлах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг нийт хамт олонд тайлагнадаг.

4.4. Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо
- Суралцагчдын үзүүлсэн амжилтууд
- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтөд хамарсан оюутны тоо олон байгаа нь маш сайн үзүүлэлт билээ.
- Захирлын нэрэмжит стипенд, тэтгэлэг авч буй оюутны тоо олон байна.

4.5. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдын шилжилт хөдөлгөөн харьцангуй бага байна.
- Шилжин ирэх суралцагчдын тоо 2,7 дахин их байгаа нь сургалтын чанар, суралцагч, төгсөгчдийн чадвар зохих түвшинд буйг харуулж байна.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1. Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого
- Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна. сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал

-
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэх үе шат бүрт гарч буй багшийн хэрэгцээг ханган ажилласнаар тайлангийн хугацаанд багшийн тоо өссөн байна. Багшийг нийтлэг журмын дагуу сонгон шалгаруулахын зэрэгцээ сургалтын технологи, арга зүйг мэддэг ахлах курсийн оюутнуудаас багшлах сонирхолтой суралцагчийг сонгон шалгаруулж, үе шаттайгаар багшийн нөөцийг бэлдэж байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтэнд эерэгээр нөлөөлж байна.
- Залуу багш нарыг хөгжүүлэх, чадваржуулах, магистрантур, докторантур, резентурт суралцуулах, багшлах ур чадварыг сайжруулахын тулд сурган заах арга зүй, мэргэжлийн болон төгсөлтийн дараах шатны сургалтанд хамруулж, санхүүгийн дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ судалгаа шинжилгээний ажлын арга зүй, орчин нөхцөл, техник хэрэгсэл, туршилтын амьтнаар хангаж байна.
- Тодорхой амжилт гаргасан багш нарыг шагналд тодорхойлох, шагнаж урамшуулах, сургалтын төлбөрийн тодорхой хэсгийг хөнгөлөх, гадаадын лаборатори, сургалт эрдэм шинжилгээний байгууллагад томилон ажиллуулах, нэмэлт цалин урамшуулал олгох зэрэг хэлбэрийг багшийн хөгжил, багшийн ажлын үнэлгээнд хэрэглэдэг.
- Сургуулиа амжилттай суралцан, төгсөгчдөөс сонгон шалгаруулж, нөөц багшаар 2 жил ажиллуулж, магистр, докторантурт суралцах боломж нь багшийн нөөцийг бүрдүүлж байна.
- Нийт 78 багшийн 15 нь эрдмийн зэрэг, цолтой байгаа нь 19-23 хувийг эзэлж байна.
- Багш, суралцагчдын харьцаа нь 1:13 байгаа нь улсын дунджаас өндөр үзүүлэлт.
- Багшлах бүрэлдэхүүний зохистой харьцаа нь багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг хангажээ.
- Багш нарын сургалтын кредит тооцох дүрмийг авч үзсэн.

5.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Багшийн мэргэжил; заах аргазүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны аргазүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт
- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал
- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжүүлэх, чадваржуулах сургалтыг 2012-2017 онд зохион байгуулжээ.
- Дотоод, гадаадын их, дээд сургуультай байгуулсан хамтын гэрээгээр багш нар мэргэжил дээшлүүлэх сургалт, туршлага судлахад үйл ажиллагаанд идэвхтэй оролцжээ.

5.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал
- Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- 2003-2017 онд эрдэм шинжилгээний цогц лабораторийг байгуулж, судалгаанд суурилсан сургалтыг эрхэлсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эерэгээр нөлөөлжээ.

-Тайлангийн хугацаанд 3 төсөл, 2 үр дүнгийн даалгавар биелүүлсэн нь байна.

-Судалгааны ажлын үр дүнгээр, хөтөлбөрийн өнөөгийн байдал, хэтийн төлөвийг урьдчилан тодорхойлсон.

-Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, ишлэгдсэн байдал шаардлагыг бүрэн хангасан.

5.4 Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/
- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа
- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал
- Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх
- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх, үр дүнг тооцох ажлын тайланг дутуу бичсэн байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ байгууллагын харьцуулсан шинжилгээ
- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал
- Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.
- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал
- Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал
- Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал
- Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- “Шинэ Анагаах Ухаан” их сургуулийн сургалт нь мэдлэг алгасахгүй байх зарчим, мэдлэг эзэмшилт масстай байх (заавал оюутанд харуулах үзүүлэх бодитой судлагдахуунтай байх) зарчим, нэр томьёо нь тодорхой байх зарчим, дэлхийн шинжлэх ухаанд тухайн сургуулийн эрдэмтдийн өөрийн бүтээсэн мэдлэгийн “сателлит-орон зай”-тай байх зарчим, хүн төрөлхтөний бий болгосон УАУ, Орчин үеийн анагаах ухаан, “Амьд эсийн доторхи мембран-редокси потенциалын гурван төлөвт шугам хамааралт протон, электроны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээний онолд суурилсан NCM анагаах ухаан гэсэн гурвалсан цогц чадамжийн зарчмууд дээр тулгуурлан шинэлэг байдлаар зохион байгуулагдаж байна.
- УАУ-D091701 хөтөлбөрийн хүрээнд сургалтын батлагдсан хөтөлбөрт багтах бүх хичээлүүдийн агуулгын 10 орчим хувийг хөтөлбөр хэрэгжүүлэгч профессорын багаас дэвшүүлсэн шинэ үзэл баримтлал, шинэ мэдлэгийн агуулгаар баяжуулан зааж байгаа нь их сургууль мэдлэгт суурилсан, шинжлэх ухаанд суурилсан сургалт, судалгаа, инновацийг бий болгох ёстой гэсэн төр засгийн бодлоготой уялдаж байна.
- Сургалтын арга зүй, сургалтын төгсгөлд оюутныг үнэлэх зарчим нь ном сурах бичгээс олж авсан мэдлэг, багшийн өгсөн мэдлэг, сургалтын хөтөлбөрийн хүрээнд бий болсон шинэ мэдлэгийн агууламжийг оюутан хэрхэн эзэмшсэнийг зөвхөн

үнэлээд зогсохгүй энэ олж авсан мэдлэгийг оюутан хэрхэн бүтээлчээр задалж, тэлж, өөрийн болгож байгаа бүтээлч ажиллагааг хөхүүлэн дэмжих зарчмыг баримталдаг.

-Хөтөлбөрийн нийт багц цагийн 3 хувийг сонгон суралцах хичээл эзэлж буй нь маш бага байна.

-Хичээлийн онол, практикийн зохистой харьцаа 1:2 байгаа нь лекц, дадлага, бие даалтын цагийн харьцаа бөгөөд хэмжээ нь түүнийг судлах цаг, агуулгын багтаамжаас хамаарах нь хоёрдмол утгыг агуулж байна /184х/.

-Зайн, цахим хичээлийг E-контент түвшинд боловсруулан, E-сургалтын бэлтгэл ажлыг хангаж байна.

-Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог босоо ба хэвтээ тэнхлэгээр хангаж байна.

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал
- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа
- Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын арга зүйг уламжлалт болон орчин үеийн анагаахын шинжлэх ухааны нээлт, ололт амжилтанд үндэслэн, шинэчилж боловсруулжээ.
- Сургалтын арга зүй нь мэдлэгийг бүтээж, хэрэглэхэд суралцах үйл явцыг хүснэгтээр илэрхийлсэн нь сурах арга барилыг тодорхойлжээ.
- Сургалтын компьютер, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын байдал 2012-2016 онд сайжирчээ.
- Дэвшүүлж буй онолын үзэл санаа нь хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүйн шинэчлэлийн үндэс болж байна.

6.3. Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал

- Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал
- Суралцагчийн гаргаж буй амжилтууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны мэдлэг, чадвар, хандлагын төлөвшлийгүнэлдэг асуулга, шалгалтын арга зүйг байнгасайжруулан, тэднийг хий, бадгана, шарын кодчилолын онолын түвшинд дүгнэдэг байна.
- Хичээл бүрийн үнэлгээний арга, хэлбэрийг 2005-2016 онд 7 удаа өөрчилж сайжруулсан нь оюутан өөрийгөө хөгжүүлэх чухал хүчин зүйлс болж байна.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал
- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багаас дэвшүүлсэн “Амьд эсийн доторх мембран – редокси потенциалын гурван төлөвт шугам хамааралт протон, электроны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээ” гэсэн шинэ санааг хамарсан сургалтын агуулга, түүний шинжлэх ухаанч шийдлийг “Шинэ Анагаах Ухаан” их сургууль үе шаттайгаар хэрэгжүүлжээ.
- Хөтөлбөр хэрэгжилтийн явцад шинэ мэдлэг бүтээх, сургалтыг шинжлэх ухаанд тулгуурлан явуулах, суралцагч, төгсөгчдөд эмнэлзүйн тодорхой асуудлыг цогцоор шийдэхэд олж авсан мэдлэгээ бүтээлчээр ашиглах чадамж эзэмшүүлэх чиглэлд ажиллаж байгаа нь “Шинэ Анагаах Ухаан” их сургуульд хэрэгжиж буй хөтөлбөрийн гол үр дүн болсон байна.
- Залуу докторууд 40% эзэлж, төгсөгчидийн ажил эрхлэлт 75,1% байгаа нь хөтөлбөрийн үр нөлөөний үнэлгээ сайн байгааг харуулж байна.
- IRIMongolian “Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан судлах нь “ зөвлөх үйлчилгээтэй хамтран судалгаа явуулахад ажил эрхлэлт 2014 75,4%, 2015

79,6% болж өссөн. 72,3% нь төгсөөд шууд ажилд орсон. Төгсөгчидийн эмч -62,28%, **УАУ эмч 22%, ОУАУ 36,9% үүнээс их эмчээр 33,8%** эзэлж байгаа нь тус мэргэжлийн хөрвөх чадвартайг харуулж байна. Сэтгэл ханамж 92,2% нь мэргэжилдээ сэтгэл хангалуун байгаа нь тус хөтөлбөрийн үр нөлөөний үнэлгээ сайн байгааг харуулж байна.

- Ажил олгогч 58 байгууллага, аж ахуйн нэгжээс үүрэн холбоогоор 40 байгууллагатай холбогдсон. Ажлын байранд тавигдах шаардлагад 67,5% нь нийцсэн гэж үзсэн байна. 2014 төгсөгчид сэтгэл ханамж 60 дээш хувьтай байна гэж үнэлсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөдөлмөрийн зах зээл зохицох байдал 59,2 хувьтай байгааг цаашид хөтөлбөрийн агуулгыг сайжруулах замаар анхаарах хэрэгтэй байна гэж дүгнэж байна.

Зөвлөмж:

- Төгсөгчидтэй хийсэн уулзалтын үеээр уламжлалтын эмч нарыг нарийн мэргэжлээр сургах үүднээс төгсөлтийн дараах сургалтыг уламжлалтын дотрын, мэдрэлийн, хүүхдийн, гэмтлийн, эмэгтэйчүүдийн гэх мэтээр дагнасан чиглэлээр хөгжүүлэхэд анхаарах.
- Хувь хүний хөгжил сурах арга барил дээр хослуулан хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.
- Цаашдаа төгсөгчдийн дунд зохиох ажлыг төлөвлөх, төгсөгчдийг ажлын байраар хангаж буй ажил олгогчидтой ойртож ажиллах, төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа явуулах, хөтөлбөрийн хүрээнд шинээр бий болж буй шинэлэг зүйл, шинэ мэдлэгийг төгсөгчдөд хүргэх, сурталчлах, эргэх холбоог үүсгэх чиглэлд анхааран ажиллах нь зүйтэй.

7.2.Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд
- Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь
- Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол улсын стандарт MNS5323:2012, УИХ-ын 1999 оны 46 тогтоол зэрэг баримт бичиг хүний бие 7 тамир, 3 хир, 5 махбод, ХШБ аас тогтдог гэсэн буруу тодорхойлолтойгоор дээрх баримт бичгүүдийн заалтийг хэрэгжүүлэх гэж оролдож байсныг шинэ анагаах ухааны онол бий болгон өөрчилсөн байна.
- Тус сургууль нь дараахь шинэ онолыг хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байгаа юм байна. Тухайлбал: Мембран редокси потенциалын 3 төлөвт шугамын онол, Хүний биеийн 4 компартмент бүтцийн онол, Эсийн шинэ баяжуулсан тодорхойлолтын онол, Протоны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээний онол, Амьд эсийн эволюци хөгжлийн

сүүлийн 4 тэрбум жилийн систем хандлагын онол, Дөрвөн гол хувилбарт эсийн популяцийн онол, 10 тогтолцоот хэсэг

- ШАУИС-ийн хөтөлбөрөөр төгсөгчидийн амжилт 2012-2016 онд 4 дэд доктор хамгаалсан байна.
- Салбар хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурийг Forbes Mongolia сэтгүүлийн захиалгаар М-ПИ-ЭС ХХК, М-ЖИ-ЭЛ интернэшнл, ЭРЖ Монголиа ХХК хамтран “Монголын их, дээд сургуулиудын чансаа-2014” судалгаагаар 8 дугаарт орж В+ эрэмблэгдсэнээр тодорхойлсон байна.
- Үндэсний Бизнес Хөгжлийн Нэгдэл төрийн бус байгууллагын зүгээс Монгол улсын судалгааны (MNS ISO 20252:2012) стандартын дагуу үндэсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чиглэлээр тогтмол судалгаагаар Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэрийг үнэлж МОНГОЛ ЧАНАР хүндэт цом өргөмжлөлөөр шагнуулсан.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцаж буй гадаад оюутны тоо
- Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжил
- Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчидийн хувь

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- “21 зуун дахь уламжлалт анагаах ухааны боловсрол” ген-энзим-субстрат-гадаад шинж - s-NCM танин мэдэхүйн тайлалаар холбож протоны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээ шинэ онол дээр тулгуурласан NCM анагаах ухааны гурвалсан тогтолцоот сургалтын технологи хэрэгжүүлсэн байна.
- Хөтөлбөрийн гарц болох эмчлэх эрхийн лицензийн шалгалтын үр дүн жил бүр 80,9 хувийн амжилттай тэнцдэг нь үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөх нотолгоо болсон байна.
- “Academia Journal of Scientific Research” сэтгүүлийн шинжээчийн үнэлгээгээр тус хөтөлбөрийг үр дүндээ хүрч байгааг тодорхойлсон байна.
- Гадаад оюутан нэг 2012-2017 онд сурч төгссөн 20 % хүргэх зорилт тавьсан байна.
- Сургуулт хөгжүүлэх мастер төлөвлөгөө /2016-2024/-нд Олон улсын магадлан итгэмжлүүлэх зорилт тавин ажиллаж байгаа юм байна.
- Оюутан, солилцоо, багш солоилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх зорилтыг мастер төлөвлөгөөнд тусган ажилаж байгаа юм байна.

7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал
- Вeбсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Япон, ОХУ, Польш улс, Азийн боловсролын хурлуудад илтгэл хэлэлцүүлжээ.
- М.Амбага багшийн онолоор цуврал лекц нь олон нийтийн мэдээлэлийн хэрэгслээр гардаг.
- Ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлдэг хэсгүүдтэй туршлага солилцдог.
- Гадаадад хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээл 9 дахин нэмэгдсэн.
- NCM–д суурилсан Уламжлалт анагаах ухааны сургалтын хөтөлбөрийн шинжлэх ухааны танин мэдэхүйн гол үндэслэл нь IF (7 оос дээш) өндөртэй сэтгүүлд 30 гаруй өгүүллийг дээрх онолын хүрээнд нийтлүүлсэн байна.
- 9 удаагийн телевизийн нэвтрүүлэг, сонинд 3 удаа нийтлэл хэвлүүлсэн нь шинэлэг менежмент болжээ.
- ОХУ Сибирийн АУС, Буриадын АУС дээр тус тус лекц уншжээ.
- www.ncd.edu.mn www.facebook.com/ncmuniversity

сургуулийн мэдээлэлийн үйл ажиллагаа тогтмолжсон гэж үзэхээр байна.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

8.1. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал
- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

-
- “Шинэ Анагаах Ухаан” их сургуульд хэрэгжүүлж буй УАУ-D091701 хөтөлбөрийн төлөвлөлт, явц хэрэгжилт, ахиц дэвшил, алдаа дутагдал, хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудын идэвх, санал санаачлага, оролцоонд судалгаа хийх, үнэлэх, чанарын баталгаа гаргах ажлыг зохих түвшинд явуулж ирсэн байна. Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах, ахиц дэвшилд хүргэх, хөтөлбөрийн агуулга, гол санааг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэх чиглэлээр сургуулийн эрдэмтэд багагүй ажлыг хийсэн байна.
 - Тус сургуулийн дотоод чанарын үйл ажиллагаа нь 2012 оноос эхлэн дотоод хяналт шинжилгээ үнэлгээний алба нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд 2017 оны 12 сарын 28-ны өдрийн А/15 тоот “Дотоод чанарын баталгаажуулалтын албаны бүтэц, дүрэм, журмыг шинэчлэн батлах тухай” тушаалаар бүтэц бүрэлдэхүүн шинэчлэгдэн сургуулийн сургалтын хөтөлбөрийн чанар баталгаажуулалтын төлөвлөгөө, Дотоод чанарын баталгаажуулалтын албанд мөрдөх журмыг боловсруулан батлуулан ажиллажээ.
 - Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, оюутны сэтгэл ханамжийн судалгаа, багш нарын сэтгэл ханамжийн болон өөрийн үнэлэх судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн эрүүл мэндийн байгууллагын судалгаа, УАУ их эмчийн ажлын байрны судалгаа (МУ-ын эрүүл мэндийн байгууллагын бүтэц үйл ажиллагааны стандарт) зэргийг хийсэн байна.
 - Оюутны сэтгэл ханамжийн судалгаа 533 оюутнаас, багшийн өөрийн үнэлгээний хуудсаар 52 багшаас, багшийн сэтгэл ханамжийн судалгааг 42 багшаас тус тус аваад үр дүнг боловсруулан шинжилж, тайланг боловсруулан ажилласан байна.
 - Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэх талаар “Уламжлалт Анагаах Ухаан-D091701” хөтөлбөрөөр төгсөгчдийн эмчлэх эрхийн зөвшөөрөл авах шалгалтын дүнгээс харахад тус мэргэжлээр төгсөгчдийн үзүүлсэн амжилтыг сүүлийн 7 жилийн дундажаар 80.9 байгаа нь манай хөтөлбөрөөр суралцаж төгссөн эмч нарын чанар, мэдлэг олголт зохих түвшинд байгааг харуулж байна.
 - Тус сургуулийн уламжлалт анагаах ухааны хүний их эмч мэргэжилтэн бэлтгэж байгаа бөгөөд 2014, 2015 онд төгссөн төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар Бизнес эрхлэх ур чадвар дээр сэтгэл ханамж бага байгаа нь анагаах ухааны мэргэжлийн онцлогтой холбоотой байна. Тиймээс цаашид төгсөн гарч буй төгсөгчийн бизнес эрхлэх чадваруудыг хөгжүүлэх тал дээр анхаарч 2016 оны УАУ-091701-ийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахдаа эдийн засгийн онол 1 кр, менежмент 1 кр, эмнэлгийн удирдлагын менежмент 1 кр гэсэн 3 хичээлийг сонгон судлах хичээлээр судлуулж байгаа ажээ.
 - ШАУИС-ийн уламжлалт анагаах ухааны хүний их эмч мэргэжилтэн бэлтгэж байгаа бөгөөд 2014, 2015 онд төгссөн төгсөгчдийн дунд сургалтын хөтөлбөрийн давуу, сул талыг судлан үзэхэд хөдөлмөрийн зах зээлд зохицох байдал 31.7 хувь нь сул талтай гэж үнэлгээ өгсөн байна. Бусад мэргэжил хөтөлбөрөөр суралцах байдал сул байгаа нь анагаах ухааны сургалтын хөтөлбөрөөр суралцах хугацаа харьцангуй урт байгаатай холбоотой гэж үзсэн байна.
 - Ажил олгогчдын зүгээс төгсөгчдийн мэргэжлийн ур чадварын талаарх дундаж үнэлгээг судлан үзэхэд “Шинэ Анагаах Ухаан” их сургуулийн нийт төгсөгчдийн 75 хувьд нь сэтгэл ханамжтай байгаа бол 25 хувь нь эргэлзсэн буюу сэтгэл ханамж дундуур байв. Ажил олгогчдийн зүгээс хамгийн өндөр сэтгэл ханамжтай ур чадвараар төгсөгчдийн харилцааны ур чадварыг онцолж байгаа нь манай сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгад буй харилцааны сэтгэл, анагаах ухааны зурхай, эмнэлгийн эрх зүй, оюуны өмчийн эрх зүй, эмчийн эрхзүй зэрэг харилцаа, хандлага, ёс зүйн хичээлүүд түлхүү орж байгаатай холбоотой гэж үзсэн байна.
 - Төгсөгчдийн манлайлах болон удирдан зохион байгуулах чадвар сул байгаа нь тухайн төгсөгчдийн хувьд хөдөлмөрийн зах зээл дээр анхны жил ажиллаж

байгаатай холбоотой байж болох талтай ч цаашид Нийгмийн эрүүл мэнд, статистик удирдлага хичээлийг сургалтын хөтөлбөрт тусгахаар төлөвлөн ажиллаж байгаа юм байна.

Анхаарах асуудал:

- Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны 4 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаал болох “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг “Хөтөлбөрийн хороо” үнэлэхдээ дараах чиглэлээр судалгаа хийж, дүгнэн шинжилэхээр заасан байдаг. Үүнд: *Сэтгэл ханамжийн үнэлгээ (төгсөгчдөөс, Явцын үнэлгээ (оюутны ахиц дэвшилд үе шаттай хийх үнэлгээ), Гүйцэтгэлийн үнэлгээ (Ажил олгогч, мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ), Үр нөлөөний үнэлгээ (мэргэжлийн салбар дахь нөлөөллийг үнэлэх) хийхээр заасан байдаг. Үүнтэй холбогдуулан оюутны ахиц дэвшилд үе шаттай үнэлгээ хийх шалгалтыг зохион байгуулж хэвших тухайлбал: 1, 2 дамжааны төгсгөлд оюутны онолын мэдлэгийн түвшинг нэгтгэн дүгнэж, цаашид суралцах эсэхэд үнэлгээ өгдөг байх*

Зөвлөмж:

- “Уламжлалт анагаах ухаан” сургалтын хөтөлбөрийн цогц чадамжийн хүрээг тодорхойлон түүнд чиглэсэн судалгаа явуулах
- Дотоод чанарын баталгаажилтын албаны үйл ажиллагааг тогтмолжуулах
- Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг тогтмолжуулах
- Цаашдаа төгсөгчдийн дунд зохиох ажлыг төлөвлөх, төгсөгчдийг ажлын байраар хангаж буй ажил олгогчидтой ойртож ажиллах, төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа явуулах, хөтөлбөрийн хүрээнд шинээр бий болж буй шинэлэг зүйл, шинэ мэдлэгийг төгсөгчдөд хүргэх, сурталчлах, эргэх холбоог үүсгэх чиглэлд анхааран ажиллах нь зүйтэй.

8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шинэ анагаах ухаан их сургуулийн “Уламжлалт анагаах ухаан” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИУЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/ Ч.Чимэдрагчаа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ Б.Даваажав /

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ Б.Цэрэнцоо /

Шинэ анагаах ухаан их сургуулийн “Уламжлалт анагаах ухаан” боловсрол бакалаврын сургалтын хөтөлбөр дээр ажиллах шинжээчдийн ажлын хуваарь

2018 оны 2 дүгээр сарын 1, 2

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
2018-02-01 Пүрэв гараг		
09:00-10:30	Зохицуулагч шинжээчийн багийг танилцуулна	Зохицуулагч
	Шинжээчийн багийн ахлагч үг хэлнэ: - Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах	Шинжээчийн багийн ахлагч
	Сургуулийн захирал үг хэлнэ	Өөрийн үнэлгээний багийн ахлагч
	Удирдлага болон ӨҮ-гийн багтай уулзах: - Удирлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга	Шинжээчийн багийн ахлагч
10:30-12:00	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана	Шинжээчид
12:00-13:00	Сургуультай танилцах аялал	Шинжээчид
13:00-14:00	Өдрийн хоол	
14:00-16:00	Оюутнуудтай хийх уулзалт	Шинжээчид
	Багш нартай хийх уулзалт	Шинжээчид
16:00-17:00	Ажил олгогчидтой хийх уулзалт	Шинжээчид
17:00-18:00	Төгсөгчидтэй хийх уулзалт	Шинжээчид
2018-02-02 Баасан гараг		
09:00-10:00	Шинжээчид номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцана	Шинжээчид
10:15-11:15	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах	
11:30-12:30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	
12:30-13:30	Өдрийн хоол	
13:30-14:30	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах	
14:30-17:00	Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн, гаргана. Нэмэлт материал үзэх танилцах /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/	
17:00-18:00	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.	

V.Оролцогчдын нэрс

I. Ярилцлаганд оролцсон багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажил-ласан жил	Заадаг хичээл
1	Б.Наранцэцэг	Эмзүйн сургуулийн захирал, Хулж боржигон эмнэлгийн дарга	АУ-ны доктор	12	НСМ-Анагаах ухааны эмнэлзүйн асуудал
2	Ц.Мөнхтуяа	ТДСА-ы дарга, тэнхмийн эрхлэгч	АУ-ны доктор	16	Уламжлалт анагаах ухааны эм судлал
3	Ш.Жаргалсайхан	Багш	АУ-ы доктор, мэс заслын ТЗЭ, клиникийн профессор, зэвсэгт хүчний хурандаа	4	Ерөнхий мэс засал
4	О.Оюунбилэг	Тэнхмийн эрхлэгч, багш	АУ-ны доктор	3	Зүрх судлал, үений эмгэг судлал
5	Д.Мөнхцэцэг	Багш	АУ-ны магистр	11	Эмгэг физиологи
6	Р.Ёндонпэрэнлэй	Багш, менежер	АУ-ы магистр, докторант	7	Микробиологи, дархлал судлал
7	Л.Пүрэвдулам	Багш	АУ-ы магистр	9	Төвөд хэл
8	Т.Эрдэнэболд	Багш, тэнхмийн эрхлэгч	АУ-ы магистр, докторант	8	Биологи, ургамал судлал
9	Б.Шүрэнцэцэг	Багш	Боловсрол судлалын магистр	5	Англи хэл
10	Б.Сугармаа	Багш	АУ-ны магистр	3	НСМ-Анагаах ухааны эмзүйн асуудал
11.	Б.Уртнасан	Багш	АУ-ны магистр, докторант	3	Анатоми

II. Оюутны нэрс

Д/д	Оюутны овог, нэр	Курс	Ямар шалтгаанаар
1	Ганбат Мөнхдагина	УАУ-I	Шилдэг оюутан
2	Пүрэвжал Мөнххүслэн	УАУ-I	Дотуур байранд амьдардаг
3	Ганхуяг Мөнхтулга	УАУ-II	Оюутны зөвлөлийн дарга
4	Доржпалам Базаргүр	УАУ-III	Дотуур байранд амьдардаг
5	Батболд Минжин	УАУ-III	Шилдэг оюутан
6	Төмөрхуяг Цэнгэлсүрэн	УАУ-IV	Шилдэг оюутан
7	Амгалан Загасаахүү	УАУ-IV	Дотуур байранд амьдардаг
8	Баярсайхан Мөнгөлүн	УАУ-IV	"Innovate" клубын тэргүүн

9	Мөнхдэлгэр	УАУ-IV	МҮИС-иаас шилжиж ирсэн.
10	Рэнцэндорж Гал-Эрдэнэ	УАУ-V	“Оюуны эрэл” клубын тэргүүн
11	Мөнхөө Анхбаяр	УАУ-V	ӨМӨЗО-ы УАУ-ы сургуулиас шилжиж ирсэн.
12	Баянбилэг Хишиг-Эрдэнэ	УАУ-V	НСМ-Анагаах Ухааныг хэн сайн ухааран ойлгосон бэ? Тэмцээний идэвхитэй оролцогч
13	Ганбаатар Энхбаатар	УАУ-V	Шилдэг оюутан
14	Отгонтогтох Тамир	УАУ-V	НСМ-Анагаах Ухааныг хэн сайн ухааран ойлгосон бэ? Тэмцээний идэвхитэй оролцогч
15	Отгонбаатар Хишигтогтох	УАУ-VI	НСМ-Анагаах Ухааныг хэн сайн ухааран ойлгосон бэ? Тэмцээний идэвхитэй оролцогч, ялагч
16	Батлут Элбэгдорж	УАУ-VI	“МАИДСОНК” клубын тэргүүн
17	Энхтөр Алтансүвд	УАУ-VI	“НСМ”-клубын ахлагч
18	Энхбаатар Гончигханд	УАУ-VI	Оюутны зөвлөлийн гишүүн
19	Дарханбаатар Нямгэрэл	УАУ-VI	Шилдэг оюутан

III. Ажил олгогч

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Д.Шагдарсүрэн	“Долмалин” эмнэлэг	Ерөнхий захирал
2	Б.Цэнгэлмаа	СХД 23-р хороо “Гурван жаргал хайрхан” ӨЭМҮТ	Эмнэлгийн дарга
3	С.Цэвэлмаа н.Оюунсүрэн	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг	Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Хүний нөөцийн дарга
4	н.Оюунчимэг	СХДЭМТ	Сувилахуйн албаны дарга
5	Т.Цэцгээ	Энэрэл эмнэлэг	Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
6	н.Оюунтунгалаг	ГССҮТ	Хүний нөөцийн дарга

IV. Төгсөгчид

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	П.Тогтох-Эрдэнэ	2011	ХУДНЭ	Дотрын их эмч
2	Т.Өнөржаргал	2005	БГДЭМТ	Мэдрэл судлалын их эмч
3	С.Лхагвасүрэн	2016	ЭМХТ	Зүүний резидентур
4	П.Мягмарцогт	2013	ГССҮТ	УАУ-ы их эмч
5	Э.Санжаадорж	2010	БХТТАНХЭ	УАУ-ы их эмч
6	Г.Орхонтуяа	2015	“Шинэ Анагаах Ухаан” Их сургууль	Багш

7	Б.Бямбацогт	2014	БНСАУ-ийн “Daegn university”	Магистрант
8	Б.Оюунцэцэг	2014	Долмалин эмнэлэг	УАУ-ы их эмч
9	Г.Оюун-Эрдэнэ	2007	БНХАУ-д	Докторант
10	Я.Гэрэлтуяа	2007	I төрөх	Нярайн эмч
11	Н.Батцэцэг	2007	Халиун эмнэлэг	УАУ-ы их эмч
12	Г.Болорсүвд	2017		УАУ-ы их эмч
13	Л.Баттөгс	2017	“Шинэ Анагаах Ухаан” Их сургууль	Магистрант

VI.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



**“ШИНЭ АНАГААХ УХААН”
ИХ СУРГУУЛЬ**

Улаанбаатар хот, Zip code-18130
Сонгинохайрхан дүүрэг-20
Сонсголон 18130 Төвчооны зам – 5/2
Утас: 70183235 Факс: 976- 70183235
E-mail: info@ncm.edu.mn
Website: www.ncm.edu.mn

2018.02.26 № 81

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**


танай _____ № _____ -т

Зөвлөмжийн хариу хүргүүлэх тухай

“Шинэ Анагаах Ухаан” Их Сургуулийн Уламжлалт анагаах ухаан - D091701 сургалтын хөтөлбөрийн хоёр дахь шатны магадлан итгэмжлэлийн шинжээчдийн багийн дүгнэлттэй танилцаж, шинжээчдийн ирүүлсэн анхаарах асуудал, зөвлөмжийн хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Жич: Хавсралт 13 хуудастай.

РЕКТОР, ПРОФЕССОР -г



Mambaga

М.АМБАГА

*Мэргэжлийн
Зөвлөмжөөр
асуудлыг хариу
авч 115-г хариу
2018.02.27*